



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/150

Арвайхээр

Комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоолын 3.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит байгууллагуудын худалдан борлуулах үндсэн хөрөнгөд үнэ тогтоох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Үндсэн хөрөнгийн үнэлгээг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль, журмын дагуу сайтар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн үндсэн хөрөнгөд үнэ тогтоох комиссын дарга (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны “Комисс томилох тухай” A/59 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100782

Аймгийн Засаг даргын 2019 оны 06
дугаар сарын 26 ны өдрийн 1150 дугаар
захирамжийн хавсралт



ҮНДСЭН ХӨРӨНГӨД ҮНЭ ТОГТООХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Н.Ганболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн
өмчийн газрын дарга)

Гишүүд: Л.Хатанбаатар (аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн
хяналт, аудитын албаны дарга)

Н.Осоржин (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
эдийн засаг хөрөнгө оруулалт, бодлого төвөлвлөлтийн
мэргэжилтэн)

М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн
өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,
урлагийн газрын ерөнхий санхүүч)

Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын
ерөнхий санхүүч)

Б.Дэлгэрмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн
өмчийн газрын Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт
хариуцсан мэргэжилтэн)

М.Мөнхбаатар (Өвөрхангай авто тээврийн төвийн техникийн
хяналтын үзлэгийн инженер)

Д.Улам-Ундрах (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн
өмчийн газрын Архив, бичиг хэрэг, нярав)